**Жилийн үйл ажиллагааны тайлагнал /маягт 1/**

*Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.*

| | |
|---|---|
| *Тайлагнах хугацаа:* | 2025 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдөр |
| *Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар* | Компанийн нэр: Худалдаа, хөгжлийн банк ХК (цаашид “Банк” гэх)<br>УБГД:9007001015<br>Үнэт цаасны код: MN00TDB05673<br>Утасны дугаар: 11 328227 |
| *Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр* | Монголын хөрөнгийн бирж ХК |
| *Бизнесийн үйл ажиллагааны салбар* | Банк, санхүү |
| *Жилийн эцсийн санхүүгийн тайланд аудитын дүгнэлт гаргасан СЗХ-нд бүртгэлтэй аудитын компанийн нэр, бүртгүүлсэн огноо* | "БЭЙКЕР ТИЛЛИ ДАЛАЙВАН АУДИТ" ХХК, 2013/05/08 |
| *Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг* | 50,600,927 |
| *Жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр* | Бэлтгэсэн: Л.Сайнбаяр – Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх ажлын албаны Гадаад харилцааны мэргэжилтэн<br><br>Хянасан: Н.Нямсүрэн – ТУЗ-ийн нарийн бичгийн дарга |

| | | |
|---|---|---|
| 1. | *Тайлант жилийн санхүүгийн тайлан /хураангүй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/* | |
| | *Санхүүгийн байдлын үзүүлэлт* | Хавсралт 1- Санхүүгийн нэгтгэсэн тайлан |
| | *Орлогын тайлан* | |
| | *Өмчийн өөрчлөлтийн тайлан* | |
| | *Мөнгөн гүйлгээний тайлан* | |
| 1.1. | *Жилийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт* | |
| | "БЭЙКЕР ТИЛЛИ ДАЛАЙВАН АУДИТ " ХХК-ийн баталгаажуулсан тайлан<br>https://issuers.mse.mn/uploads/audit_concl_files/567_1777270570audit.pdf | |
| 1.2. | *Аудитын тодорхойлох захидал /тодорхойлох захидлыг энэхүү зааварт дурдсан агуулгын хүрээнд боловсруулсан байх/* | |
| | "БЭЙКЕР ТИЛЛИ ДАЛАЙВАН АУДИТ " ХХК-ийн баталгаажуулсан тайлан<br>https://issuers.mse.mn/uploads/audit_concl_files/567_1777270570audit.pdf | |

| | |
|---|---|
| 2. | *Үнэт цаас гаргагч нь тайлант хугацаанд санхүүгийн нөхцөл байдал, үйл ажиллагааны үр дүнд нөлөөлсөн хүчин зүйлс, удирдлагаас өгсөн үнэлгээ, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар товч тайлбарласан тайлан, мэдээлэл* |
| 2.1. | *Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/* |

| № | Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт | Байвал зохих | Банк |
|---|---|---|---|
| 1 | Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө болон эрсдэлээр жигнэсэн активын зохистой харьцаа | >9% | 14.48% |
| 2 | Өөрийн хөрөнгө эрсдэлээр жигнэсэн активын харьцаа | >13% | 14.48% |
| 3 | Гадаад валютын нээлттэй позици болон өөрийн хөрөнгийн харьцаа (Нэгж валютаар) | <+/-15% | 10.33% |
| 4 | Гадаад валютын нээлттэй позици болон өөрийн хөрөнгийн харьцаа (Нийт валютаар) | <+/-30% | 22.10% |

| | |
|---|---|
| 2.2. | *Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт* |

| № | Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт | Байвал зохих | Банк |
|---|---|---|---|
| 1 | Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлт | >25% | 43.40% |

| | |
|---|---|
| 2.3. | *Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчноос үзүүлж буй нөлөөлөл, үйл ажиллагаа явуулж буй салбарт эзлэх хувь, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөлд гарч буй өөрчлөлт, хөгжил дээрх өөрчлөлтөд үнэт цаас гаргагчийн зүгээс авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээний мэдээлэл* |

2025 онд Монгол улсын эдийн засаг 89.9 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 6.8%-аар өслөө. Хөдөө аж ахуйн салбар хамгийн том хөдөлгөгч хүч болж, өмнөх оноос 33.2%-аар өсч эдийн засгийн өсөлтийн 2.9 нэгжийг дангаараа бүрдүүлсэн байна. Мөн бусад салбар болох уул уурхай, барилга, үйлчилгээний тогтвортой өсөлт зэргийн нийлбэрээр эдийн засгийн өсөлт Монголбанк (5.8%), Азийн Хөгжлийн Банк (5.7%)-ын таамаглалаас давж, бизнесийн орчин, санхүүгийн салбарын үйл ажиллагаанд эерэг нөлөө үзүүлсэн жил байлаа.

Тайлант хугацаанд Монгол Улсын олон улсын зээлжих зэрэглэл сайжирч, Fitch агентлаг зэрэглэлийг “B+, тогтвортой”, S&P Global агентлаг “BB-, тогтвортой”, Moody’s агентлаг “B1”, тогтвортой түвшинд тус тус ахиулсан нь макро эдийн засгийн суурь орчин сайжирч байгааг илэрхийлэв. Улсын зээлжих зэрэглэл ийнхүү ахисан нь банк, санхүүгийн салбарын гадаад эх үүсвэр татах боломж, хөрөнгө оруулагчдын итгэл, санхүүжилтийн нөхцөлд эерэг суурь нөлөө үзүүллээ.

Макро орчин, зах зээлийн идэвхжилтэй уялдан Худалдаа, Хөгжлийн Банк 2025 онд өсөлт, чанар, үйлчилгээний хүртээмжийг зэрэг ахиулахад чиглэсэн бодлогоо үргэлжлүүлэн хэрэгжүүлэв. Тайлант онд банкны зээлийн багцын өсөлтөд уул уурхай, худалдаа, барилга, үйлдвэрлэлийн салбарын зээлүүдээс гадна хэрэглээний зээлийн өсөлт голлон нөлөөлөв. Хэрэглээний зээлийн сегментэд цалин болон тэтгэврийн

зээлийг 100 хувь хүний оролцоогүй, бүрэн онлайнаар харилцагчид хүргэх боломжийг бий болгосон нь хүртээмж, шуурхай байдлыг нэмэгдүүлж, зээлийн олголтын сувгийг өргөжүүлэхэд бодит дэмжлэг үзүүлэв.

Эдийн засгийн идэвхжил, харилцагчдын мөнгөн урсгалын өсөлт, мөн банкны дотоод түвшинд хэрэгжүүлсэн чанаргүй активын удирдлага, эргэн төлөлтийг эрчимжүүлэх арга хэмжээний үр дүнд чанаргүй зээлийн эргэн төлөлт сайжирч, чанаргүй зээлийн харьцаа 4.1 хувь хүртэл буурсан нь активын чанарын удирдлагын хувьд чухал ахиц байлаа. Энэ нь банк зөвхөн багцын өсөлтөөр бус, мөн зээлийн чанарыг тогтворжуулахад анхааран ажилласны илэрхийлэл болсон.

Банкны үндсэн бүтээгдэхүүн, үйлчилгээний хүрээнд томоохон өөрчлөлт ороогүй боловч санхүүжилтийн эх үүсвэрийг төрөлжүүлэх, урт хугацаатай, тогтвортой эх үүсвэрийн эзлэх хувийг нэмэгдүүлэхэд анхаарч байна. Үүний хүрээнд худалдааны санхүүжилт, бүтэцжүүлсэн санхүүжилт болон тогтвортой хөгжил, ногоон санхүүжилтийн чиглэлийн бүтээгдэхүүнүүдийг хөгжүүлэх бодлогыг баримталж байна. Эдгээр чиглэл нь олон улсын банк, хөрөнгө оруулагчид болон хөгжлийн санхүүгийн байгууллагуудын хувьд илүү сонирхол татахуйц санхүүжилтийн шийдэл болж байна.

Тайлант онд банкны олон улсын үнэлгээ, гадаад эх үүсвэр татах чадавхын хувьд мөн чухал ахиц гарлаа. АНУ-ын Засгийн газрын агентлаг болох Хөгжлийн Санхүүжилтийн Корпорациас (DFC) 2025 онд гэрээний дагуу батлагдсан 120 сая ам.долларын санхүүжилтийг бүрэн татан төвлөрүүлсэн нь банкны гадаад эх үүсвэрийн баазыг өргөжүүлэхийн зэрэгцээ жижиг, дунд бизнес эрхлэгчид, эмэгтэй бизнес эрхлэгчид, уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг чиглэсэн ногоон санхүүжилтийг дэмжих бодлоготой уялдсан стратегийн ач холбогдолтой алхам байлаа.

Санхүүгийн үзүүлэлтүүдийн хувьд банк 2025 онд өсөлтийн эрчээ хадгалж, нийт актив 21.8 хувиар, зээлийн багц 28.1 хувиар, харилцагчдаас татан төвлөрүүлсэн харилцах, хадгаламжийн үлдэгдэл 12.3 хувиар, өөрийн хөрөнгө 6.7 хувиар тус тус өслөө. Эдгээр үзүүлэлтүүд нь банкны зах зээлд эзлэх байр суурь, харилцагчийн суурь, санхүүжилтийн чадавх үргэлжлэн тэлж байгааг харуулж байгаа бөгөөд цаашид өсөлтийн хурдаа ашигт ажиллагаа, активын чанар, хөрвөх чадварын тэнцвэртэй удирдлагатай уялдуулан хадгалах шаардлагыг мөн илэрхийлж байна.

ХХБанкны зах зээлд эзлэх хувь:

| № | Үзүүлэлт | Зах зээлд эзлэх хувь | |
|---|---|---|---|
| | | 2024 | 2025 |
| 1 | Нийт хөрөнгө | 21.0% | 21.4% |
| 2 | Цэвэр зээл | 17.6% | 18.8% |
| 3 | Нийт харилцах | 23.0% | 26.2% |
| 4 | Нийт хадгаламж | 22.1% | 22.4% |

2025 онд Худалдаа, Хөгжлийн Банк харилцагч төвтэй банк, дижитал банк болох банкны урт болон дунд хугацааны стратегийн зорилтоо хэрэгжүүлэх хүрээнд бүтээгдэхүүн, үйлчилгээ, сувгийн шинэчлэл, процессын автоматжуулалт, мэдээллийн аюулгүй байдал, төлбөрийн дэд бүтцийн шинэчлэлд төвлөрөн ажиллав. Банкны стратеги, харилцагчдын эрэлт хэрэгцээ, технологийн хөгжлийн чиг хандлагатай уялдуулан нэвтрүүлсэн дараах шинэчлэлүүд нь зөвхөн шинэ үйлчилгээ гаргасан төдийгүй харилцагчийн туршлагыг сайжруулах, үйл ажиллагааны бүтээмжийг нэмэгдүүлэх, шийдвэр гаргалтын хурдыг өсгөх, эрсдэлийн удирдлагын тогтолцоог бэхжүүлэхэд чиглэв.

| | |
|---|---|
| | Дараах шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлж, хөгжүүлэлт сайжруулалтыг хийв. Үүнд:<br>1. Жижиг, дунд бизнес эрхлэгчдийн сегментэд банк POS орлого барьцаалсан зээлтэй харилцагчид ТиДиБи онлайнаар дамжуулан нэмэлт зээлийн хүсэлт гаргах, зээлийн гэрээг цахимаар баталгаажуулах боломжийг бүрдүүлж, түүнд тохирсон аюулгүй байдлын нэмэлт хөгжүүлэлтийг хийв. Үүний зэрэгцээ бизнесийн орлоготой иргэдийн орлогыг итгэлцүүр тооцоололд үндэслэн түргэн шуурхай үнэлэх аргачлалыг үйл ажиллагаанд бүрэн нэвтрүүлснээр зээлийн судалгаа, шийдвэр гаргалтын хугацааг бууруулах, харилцагчид хүрэх хурдыг нэмэгдүүлэх суурийг бүрдүүлэв. Банк өгөгдлд суурилсан шийдвэр гаргалтын үйл ажиллагаа нэмэгдүүлсэнээр илүү хурдтай ажиллах арга барил, харилцагчийн хэрэгцээнд нийцсэн санхүүжилтийн шийдлийг өргөжүүлж буйн илэрхийлэл боллоо.<br>2. Иргэдийн зах зээлээ тэлэх чиглэлийн хүрээнд дараах шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд нэвтрүүлэв.<br>1) Цахим төлбөр тооцооны хялбар шийдэл болох Happy pay цахим хэтэвчийг зах зээлд шинээр нэвтрүүллээ.<br>2) Гэр бүлд зориулсан “Happy family” багц бүтээгдэхүүн болон Britto visa картын дараагийн цуврал болох хүүхдийн Britto puppy картаа зах зээлд нэвтрүүллээ.<br>3) Андройд үйлдлийн системтэй ухаалаг утас хэрэглэгч харилцагчдадаа зориулан дэлхийн төлбөр тооцооны шилдэг шийдлийн нэг болох Google pay үйлчилгээг нэвтрүүллээ.<br>4) Харилцагч ТиДиБи онлайнаар дамжуулан автомашины зээлийн хүсэлт илгээхээс эхлүүлэн зээл авах хүртэлх үйл ажиллагааг бүрэн автоматжуулав.<br>5) Хадгаламж барьцаалсан зээлтэй харилцагчид зайнаас буюу ТиДиБи онлайнаар дамжуулан зээлээ төлж, хадгаламжийн хугацааг цуцлах боломжийг бий болгов.<br>6) Харилцагч зайнаас хүүхдээ банкны харилцагчаар бүртгүүлэн хүүхэддээ карт захиалах, хадгаламж нээх үйлчилгээг авах боломжийг бүрдүүлэв.<br>3. Хиймэл оюун ухаанд суурилсан, 24/7 горимоор харилцагчдын түгээмэл асуултад хариу өгөх, бүтээгдэхүүн, үйлчилгээний мэдээллийг бодит цагийн горимоор хүргэх чат ботыг хөгжүүлэн, үндсэн үйл ажиллагаанд амжилттай нэвтрүүлэв.<br>4. ХХБ нь харилцагч төвтэй банк, дижитал банк болох стратеги зорилгын хүрээнд салбар, тооцооны төвийн өнгө төрхөө шинэчлэн, цаасгүй цахим салбарын тоог нэмэгдүүлэв.<br>5. Төлбөрийн картын мэдээллийн аюулгүй байдлын PCI DSS (Payment Card Industry Data Security Standart) стандартын шинэчлэгдсэн хувилбар буюу 4.0 хувилбарын стандартын батламжаа хүлээн авав.<br>6. БНСУ-д тэргүүлэх нүдний эмнэлэгүүдтэй хамтын ажиллагааны санамж бичиг байгуулав. Ингэснээр банкны карт эзэмшигч харилцагч нар тухайн эмнэлэгүүдэд 10-49% хөнгөлөлт эдлэх боломжийг бүрдүүлэв.<br>7. Хуучин загварын ПОС төхөөрөмжүүдийг Андройд үйлдлийн системтэй PAX загварын ПОС-оор шинэчилж, нийт ПОС мерчантын 90 хувийг орчин үеийн, олон улсын аюулгүй байдлын стандартад нийцсэн төхөөрөмжөөр хангаж парк шинэчлэлийг хэрэгжүүллээ.<br><br>Худалдаа, Хөгжлийн Банк 2025 онд өсөлт, дижитал шилжилт, харилцагчийн туршлага, аюулгүй байдал, олон улсын түншлэл гэсэн үндсэн чиглэлүүдэд бодит ахиц гаргаж, санхүүгийн үзүүлэлтүүдийн өсөлтийг бүтээгдэхүүн, үйлчилгээ, процесс, дэд бүтцийн |

шинэчлэлээр дэмжсэн жил боллоо. Цаашид банк өсөлтийн чанар, ашигт ажиллагаа, активын чанар, технологийн найдвартай байдал, харилцагчийн үнэ цэнийг тэнцвэртэй нэмэгдүүлэх замаар тогтвортой өсөлтийн сууриа улам бэхжүүлэх төдийгүй санхүүжилтийн өртөг өсөх, зах зээлийн өгөөж тэлэх эрсдэлийг бууруулах зорилгоор олон улсын арилжааны банкууд, институциональ хөрөнгө оруулагчид болон хөгжлийн санхүүгийн корпорациудтай хамтын ажиллагаагаа идэвхжүүлэн ажиллаж байна. Тодруулбал, хоёр талт болон синдикат зээлийн шугам, худалдааны санхүүжилтийн эх үүсвэр, хөгжлийн санхүүгийн байгууллагуудаас олгогдох урт хугацаатай, харьцангуй хямд өртөгтэй санхүүжилтийг татах боломжийг судалж, хэрэгжүүлж байна. Эдгээр арга хэмжээний хүрээнд Банк нь санхүүжилтийн өртгийг хянаж барих, хөрвөх чадварын тогтвортой байдлыг хангах, улмаар геополитикийн болон зах зээлийн тодорхойгүй нөхцөл байдлын үед ч бизнесийн үйл ажиллагаагаа тогтвортой үргэлжлүүлэх зорилт тавин ажиллаж байна.

*2.4. Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлогын мэдээлэл /off balance/*

| Тэнцлийн гадуурх данс | MNT’000 |
|---|---|
| Зээл, зээлтэй адилтгах хөрөнгөд хамаарах үүрэг (цэвэр дүнгээр) | 1,534,878,776 |

*2.5. Тайлант хугацаанд авсан зээлийн эргэн төлөлт болон зээлийн барьцаа, баталгааны талаарх мэдээлэл;*

| | 'MNT 000 |
|---|---|
| Нийт зээл | 1,067,652,854 |
| Нийт эргэн төлөлт | 679,945,065 |

*3. Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/*

Банкны ТУЗ-өөс 2025 онд нийт 15 тогтоолоор сонирхлын зөрчилтэй хэлцэлтэй холбоотой зөвшөөрлийг олгосон ба тухайн ТУЗ-ийн тогтоолуудыг тухай бүрт нь МХБ-ийн болон өөрийн цахим хуудсаар олон нийтэд мэдээлсэн болно.

Банкны тухай хуулийн 38 дугаар зүйлд заасны дагуу банк нь холбогдох этгээдэд олгосон зээл, гаргасан аккредитив, бусад үүрэг, ажил, үйлчилгээний мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэлдэг.

2025 оны 12-р сарын 31-ний өдрийн байдлаар (сая төгрөгөөр)

| **Банкны холбогдох этгээд (нэгдмэл сонирхолтой этгээд)** | | **Активын хэлбэр** | **Үлдэгдэл дүн** | **Өөрийн хөрөнгөд эзлэх хувь** |
|---|---|---|---|---|
| 1. | Банкны холбогдох нэг этгээд (нэгдмэл сонирхолтой этгээд)-д олгосон зээл болон зээлтэй адилтган тооцох бусад актив (Өөрийн хөрөнгийн 5 хувиас хэтрэхгүй) | | | |
| 1.1. | Банкны хувьцаа эзэмшигч | Зээл, Авлага | - | - |
| 1.2. | Банкны эрх бүхий албан тушаалтан | Зээл | 990.58 | 0.06% |
| 1.3. | Банкны бусад холбогдох этгээд | Авлага | 61,996.28 | 3.77% |
| 2. | Банкны холбогдох нийт этгээд (нэгдмэл сонирхолтой этгээдүүд)-д олгосон зээл болон зээлтэй адилтган тооцох бусад актив (Өөрийн хөрөнгийн 20 хувиас хэтрэхгүй) | | | |
| 2.1. | Банкны хувьцаа эзэмшигчид | Зээл, Авлага | - | - |
| 2.2. | Банкны эрх бүхий албан тушаалтанууд | Зээл, Авлага | 4,905.43 | 0.30% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 2.3. | Банкны бусад холбогдох этгээд | Зээл, Бусад актив | 161,046.84 | 9.79% |

*Банкны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь заалтад заасны дагуу Банкны холбогдох этгээдийг тодорхойлдог.

Банк нь Тайлант хугацаанд Компанийн тухай хуулийн 87 дугаар зүйлийн 87.1 дэх хэсэгт тодорхойлсон их хэмжэний хэлцэл байгуулаагүй байна.

4. *Цалин урамшууллын мэдээлэл*

Банк нь 2022–2026 онуудад ТУЗ-өөс баталсан “Зөгийн үүр” хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэн ажиллаж байна. Уг хөтөлбөрийн хүрээнд 2025 онд нийт 2,328 ажилтны бүтээмжийн цалинг 25 хүртэлх хувиар нэмэгдүүлж, ажилтнуудын санхүүгийн сайн сайхан байдалд бодитойгоор анхаарал хандуулсан байна. Үүний үр дүнд ажилтнуудын сэтгэл ханамжийн индексийг нэмэгдүүлж, ажилтны тогтоон барих түвшнийг зорилтот түвшинд хүргэж чадсан нь хөтөлбөр амжилттай хэрэгжсэнийг харуулж байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн зардлын хэмжээг жил бүрийн ХХБ-ны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар батлуулан ТУЗ-өөр баталсан хэмжээгээр цалин хөлсийг олгодог бөгөөд ТУЗ-ийн дэргэдэх хороодын хурлыг даргалах болон оролцоонд суурилсан цалин хөлсний бодлогыг хэрэгжүүлж байна. Гүйцэтгэх удирдлагын хувьд ТУЗ-ийн дэргэдэх Цалин, урамшууллын болон нэр дэвшүүлэх хорооны хуралд хөдөлмөрийн гэрээний хугацаа дуусгавар болсон эсхүл дүгнэх шаардлага үүссэн тохиолдолд тайлан, гүйцэтгэлтэй танилцуулан холбогдох арга хэмжээг авч ажиллаж байна. Тайлант хугацаанд ТУЗ-ийн энгийн болон хараат бус гишүүд, гүйцэтгэх удирдлагын цалин, урамшууллын хэмжээ нийт цалингийн сангийн 5.5 хувь байна.

5. *Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл*

Хавсралт 2

6. *Зах зээлийн эрсдэлийн мэдээлэл*

Зах зээлийн эрсдэл гэдэг нь гадаад валютын ханш, хүүгийн түвшин, үнэт цаасны үнэ болон зах зээлийн бусад хүчин зүйлсийн өөрчлөлтөөс шалтгаалан Банкны санхүүгийн хэрэгслүүдийн үнэ цэн, ашигт ажиллагаа болон өөрийн хөрөнгөд сөрөг нөлөө үзүүлэх эрсдэл юм. Банк нь зах зээлийн эрсдэлийг батлагдсан эрсдэлийн аппетит, дотоод лимитийн тогтолцоо, Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны шаардлага болон холбогдох бодлого, журам, аргачлалын хүрээнд тогтмол хэмжиж, хянаж, удирдлагын түвшинд тайлагнан ажилладаг.

Тайлант хугацаанд дэлхийн болон дотоодын эдийн засгийн орчинд геополитикийн тодорхой бус байдал, инфляцын дарамт, бодлогын хүүгийн өндөр түвшин, гадаад валютын ханшийн хэлбэлзэл болон хөрөнгийн зах зээлийн үнэлгээний өөрчлөлт зэрэг хүчин зүйлс хадгалагдсан нь банкны салбарын зах зээлийн эрсдэлийн удирдлагын ач холбогдлыг нэмэгдүүлэв. Ийм нөхцөлд Банк нь зах зээлийн эрсдэлийг тодорхойлох, хэмжих, хянах, хязгаарлах болон болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулахад чиглэсэн хяналт, удирдлагын тогтолцоог тасралтгүй хэрэгжүүлэн ажиллалаа.
2025 онд Банк нь гадаад валютын нээлттэй позиц, хүүгийн эрсдэл болон үнэт цаасны багцын үнэлгээний өөрчлөлтийг тогтмол хэмжиж, зах зээлийн өөрчлөлтөөс үүсэж болзошгүй эрсдэлийг хянаж ажилласан.

- Гадаад валютын ханшийн эрсдэлийн хүрээнд валют тус бүрийн болон нийт нээлттэй позицийн хэмжээг Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны шаардлага, мөн

дотоод лимиттэй уялдуулан хянаж, ханшийн өөрчлөлтөөс үүсэж болзошгүй нөлөөллийг бууруулах арга хэмжээг тухай бүр авч хэрэгжүүллээ. Тус эрсдэлийг хэмжих үндсэн арга хэрэгслийн нэг болох хамгийн их эрсдэлийн /Value at Risk, VaR/ аргыг ашиглан ханшийн тааламжгүй өөрчлөлтөөс үүсэж болзошгүй алдагдлын түвшинг өдөр бүр тооцож, тооцооллын үр дүнг удирдлагын түвшинд тайлагнан, Актив, пассивын удирдлагын хорооноос баталсан лимиттэй харьцуулан хянаж ажилласан.

- Хүүгийн эрсдэлийн хүрээнд Банк нь Базел III-ын зарчимд нийцүүлэн актив, пассивын дахин үнэ тогтох хугацааны зөрүү, хүүгийн мэдрэмжтэй актив, пассивын бүтэц болон зах зээлийн хүүгийн түвшний өөрчлөлтөөс цэвэр хүүгийн орлого, өөрийн хөрөнгийн эдийн засгийн үнэ цэнэд үзүүлэх нөлөөллийг үнэлж ажиллав. Тайлант хугацаанд хүүгийн эрсдэлийн үнэлгээний үр дүнг Актив, пассивын удирдлагын хороонд танилцуулж, шаардлагатай тохиолдолд актив, пассивын бүтэц, санхүүжилтийн нөхцөл болон дотоод лимитийн хэрэгжилттэй уялдуулан, шаардлагатай арга хэмжээг авч ажиллалаа.

- Үнэт цаасны багцын хувьд зах зээлийн нөхцөл байдал, багцын бүтэц, санхүүгийн хэрэгслийн хугацаа болон үнийн мэдрэмжид тулгуурлан Базел III-ын зарчимд нийцсэн зах зээлийн эрсдэлийн өөрийн хөрөнгийн шаардлага (Market Risk Capital Charge, MRCC)-ын аргачлалаар эрсдэлийг үнэлж, зохистой хязгаарыг тогтоон мөрдөж ажилласан. Уг үнэлгээнд зах зээлийн үнэ, өгөөжийн түвшин, хүүгийн өөрчлөлтөөс үнэт цаасны үнэлгээнд үзүүлэх боломжит нөлөөллийг тооцоолохын зэрэгцээ мэдрэмжийн болон стресс тестийн шинжилгээг тогтмол гүйцэтгэн хянаж ажиллалаа.

Тайлант хугацаанд Банк нь зах зээлийн эрсдэлийн хэмжилт, лимитийн хэрэгжилтийн хяналт, стресс тестийн шинжилгээ болон удирдлагын тайлагналын тогтолцоог тасралтгүй хэрэгжүүлж, зах зээлийн орчны өөрчлөлттэй уялдуулан хяналтын аргачлал, процессыг үе шаттайгаар сайжруулан ажилласан. Цаашид Банк нь хүү, гадаад валютын ханш, үнэт цаасны зах зээлийн өөрчлөлтийг тогтмол хянахын зэрэгцээ зах зээлийн эрсдэлийн удирдлагын аргачлал, лимитийн тогтолцоо, стресс тест болон тайлагналын чанарыг үргэлжлүүлэн бэхжүүлэх зорилт тавин ажиллана.

7. *Хувьцаа эзэмшигчдийн өмчлөлийн мэдээлэл /5 ба түүнээс дээш хувьцаа эзэмшигчдийн нэрс эзэмшилийн хувь, нийт хувьцаа эзэмшигчдийн тоо/*




НИЙТ ГАРГАСАН ХУВЬЦААНЫ ТОО

**50,600,967**

НИЙТ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ

**2,829**

*2025/12/31-ний өдрийн байдлаар*

| | |
|---|---|
| 8. | *Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойш дуусах хүртэл хугацаанд төслийн хэрэгжилтийн явц болон татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан мэдээлэл* |

Худалдаа, хөгжлийн банк нь татан төвлөрүүлсэн хөрөнгийг "Ногоон банк" болох урт хугацааны тэргүүлэх дэд стратеги чиглэлийн хүрээнд ХХБ-ны "Тогтвортой санхүүжилтийн хүрээ" баримт бичигт тусгагдсан ногоон болон нийгмийн зээлийн ангиллуудын шалгуур үзүүлэлтийг хангасан санхүүжилтэд бүрэн зарцуулж дуусгасан байна.

Тодруулбал, анхдагч зах зээлийн арилжаанд нийт 2'528 хөрөнгө оруулагчдаас 105.5 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий захиалга хүлээн авч, татан төвлөрүүлэх зорилтот дүн болох 83.5 тэрбум төгрөгийн захиалга 126.4% гүйцэтгэлтэйгээр 2023.05.28-ны өдөр хаагдсан.

Банк нь активын зохистой бүтцийг бий болгох, иргэд болон жижиг, дунд бизнесийн зах зээлд тэлэлт хийх стратеги төлөвлөгөөний дагуу татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтыг бизнесийн сегментүүдийн ногоон болон нийгмийн зээлийн санхүүжилтэд дараах хуваариар төлөвлөсний дагуу 2024.09.30-ны өдрийн байдлаар амжилттайгаар бүрэн гүйцэтгэж дуусгасан байна. Үүнд:

| | |
|---|---|
| Нийт татан төвлөрүүлсэн хөрөнгийн дүн | MNT 83,500,000,000.00 |
| - Үүнээс Байгууллагын сегментэд олгох дүн (50.0%) | MNT 41,750,000,000.00 |
| - Үүнээс Жижиг, дунд бизнесийн сегментэд олгох дүн (20.0%) | MNT 16,700,000,000.00 |
| - Үүнээс Иргэдийн сегментэд олгох дүн (30.0%) | MNT 25,050,000,000.00 |
| НИЙТ ОЛГОСОН ЗЭЭЛИЙН ДҮН | MNT 83,500,000,000.00 |
| **Татан төвлөрүүлсэн хөрөнгийн ашиглалтын хувь** | **100.00%** |

| | |
|---|---|
| 9. | *Ногдол ашгийн мэдээлэл* |

Тайлант хугацаанд Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн 19 тоот тогтоолоор Худалдаа, хөгжлийн банкны 2024 оны цэвэр ашгаас нийт хувьцаа эзэмшигчдийн нэгж энгийн хувьцаанд ногдол ашиг хуваарилсан.

*Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн өдөр:* 2025.04.07
*Нэгж хувьцаанд олгох ногдол ашиг*: 2,000 (хоёр мянга) төгрөг
*Нийт олгох ногдол ашгийн хэмжээ:* 101,201,854,000 (нэг зуун нэг тэрбум хоёр зуун нэг сая найман зуун тавин дөрвөн мянга) төгрөг

| | |
|---|---|
| 10. | *Үнэт цаас гаргагчаас тайланд хугацаанд нийгмийн хариуцлагын чиглэлээр хийгдсэн ажлын тайлангийн мэдээлэл* |

Хавсралт 3

| |
|---|
| Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо: |
| Овог, нэр: О.ОРХОН<br>Албан тушаал: “Худалдаа, хөгжлийн банк” ХК-ийн гүйцэтгэх захирал<br>Гарын үсэг: ……………………………………<br>*(Тамга/тэмдэг)* |
| Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо: |
| Овог, нэр: Н.НЯМСҮРЭН<br>Албан тушаал: ТУЗ-ийн нарийн бичгийн дарга<br>Гарын үсэг: …………………………………….. |

**Байгууллагын нэр: Худалдаа хөгжлийн банк**
**Регистр: 2635534**

**САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН**

/Мянган төгрөг/

| № | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл (2024.12.31) | Эцсийн үлдэгдэл (2025.12.31) |
|---|---|---|---|
| 1 | **ХӨРӨНГӨ** | - | - |
| 1.1 | **Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө** | **3,572,256,753** | **3,130,545,021** |
| 1.1.1 | Бэлэн мөнгө | 64,286,886 | 78,685,103 |
| 1.1.2 | Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан мөнгө | 1,669,655,007 | 1,231,089,462 |
| 1.1.3 | Мөнгөтэй адилтгах хөрөнгө | 1,837,294,011 | 1,820,175,329 |
| 1.1.4 | Мөнгөн хөрөнгөнд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага | 1,020,849 | 595,127 |
| 1.2 | **Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө** | **2,756,341,403** | **4,622,059,198** |
| 1.2.1 | Монголбанкинд байршуулсан хөрөнгө | 2,756,935,248 | 4,622,372,134 |
| 1.2.2 | Бусад банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө | - | - |
| 1.2.3 | Бусад хөрөнгө | - | - |
| 1.2.4 | Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгөнд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага | - | - |
| 1.2.5 | Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгийн эрсдэлийн сан | (593,845) | (312,936) |
| 1.3 | **Хөрөнгө оруулалт** | **1,066,849,253** | **1,231,647,017** |
| 1.3.1 | Арилжааны үнэт цаас | - | - |
| 1.3.2 | Борлуулахад бэлэн үнэт цаас | 1,040,448,518 | 1,189,691,963 |
| 1.3.3 | Хугацааны эцэс хүртэл эзэмших үнэт цаас | - | 9,665,545 |
| 1.3.4 | Зээл ба авлага гэж ангилсан бусад үнэт цаас | - | - |
| 1.3.5 | Хараат, хамтын хяналттай, охин компанид оруулсан хөрөнгө оруулалт | 164,244 | 1,769,992 |
| 1.3.6 | Барьцаанд байгаа үнэт цаас | - | - |
| 1.3.7 | Үнэт цаасанд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага | 26,236,491 | 30,552,896 |
| 1.3.8 | Үнэт цаасны эрсдэлийн сан | - | (33,379) |
| 1.4 | **Зээл (цэвэр дүнгээр)** | **6,179,569,553** | **7,919,104,322** |
| 1.4.1 | Хэвийн зээл | 5,680,941,171 | 7,534,221,952 |
| 1.4.2 | Хугацаа хэтэрсэн зээл | 409,081,945 | 289,336,647 |
| 1.4.3 | Хэвийн бус зээл | 90,870,751 | 30,816,068 |
| 1.4.4 | Эргэлзээтэй зээл | 6,461,441 | 42,528,453 |
| 1.4.5 | Муу зээл | 162,916,235 | 252,497,026 |
| 1.4.6 | Зээлийн хойшлогдсон төлбөр | (22,505,082) | (22,780,064) |
| 1.4.7 | Зээлд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага | 160,017,967 | 172,791,714 |
| 1.4.8 | Зээлийн эрсдэлийн сан | (308,214,875) | (380,307,473) |
| 1.5 | **Дериватив санхүүгийн хөрөнгө** | **88,784,131** | **86,412,028** |
| 1.6 | **Бусад санхүүгийн хөрөнгө** | **113,516,923** | **67,187,369** |
| 1.6.1 | Бусад санхүүгийн хөрөнгө | 101,901,106 | 53,863,780 |
| 1.6.2 | Банк, салбар хоорондын тооцоо | 9,475,546 | 10,551,010 |
| 1.6.3 | Өмчлөх бусад хөрөнгө (цэвэр дүнгээр) | - | - |
| 1.6.4 | Бусад | 2,140,271 | 2,772,579 |
| 1.7 | **Бусад санхүүгийн бус хөрөнгө** | **441,793,726** | **473,336,912** |
| 1.7.1 | Бусад тооцоо | 36,142,983 | 51,111,916 |
| 1.7.2 | Бараа материал, үнэ бүхий зүйл | 14,513,521 | 5,606,155 |
| 1.7.3 | Үнэт металл (цэвэр дүнгээр) | 163,162 | 161,016,258 |
| 1.7.4 | Өмчлөх бусад хөрөнгө (цэвэр дүнгээр) | 389,450,166 | 254,433,955 |
| 1.7.5 | Татварын авлага | 1,334,843 | 1,167,988 |
| 1.7.6 | Хойшлогдсон татварын хөрөнгө | - | - |
| 1.7.7 | Бусад | 189,051 | 640 |
| 1.8 | **Үндсэн хөрөнгө** | **557,507,598** | **574,699,475** |
| 1.9 | **Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө** | **80,749,541** | **100,192,970** |
| 1.10 | **Борлуулах зориулалттай хөрөнгө** | **95,381,015** | **8,936,905** |
| 1.11 | **Биет бус хөрөнгө** | **47,618,788** | **49,905,429** |
| 1.12 | **Нийт хөрөнгийн дүн** | **15,000,368,684** | **18,264,026,646** |
| 2 | **ӨР ТӨЛБӨР** | - | - |
| 2.1 | **Харилцах** | **3,589,983,877** | **3,894,221,594** |
| 2.1.1 | Харилцах дансны нэрлэсэн үлдэгдэл | 3,589,983,300 | 3,894,221,594 |
| 2.1.2 | Харилцах дансанд хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг | 577 | 0 |
| 2.2 | **Хадгаламж** | **6,065,437,491** | **7,234,500,339** |
| 2.2.1 | Хугацаагүй хадгаламж | 646,864,177 | 752,506,300 |
| 2.2.2 | Хугацаатай хадгаламж | 5,262,513,396 | 6,284,235,497 |
| 2.2.3 | Бусад төрлийн хадгаламж | 1,155,000 | 1,142,005 |
| 2.2.4 | Хадгаламжинд хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг | 154,904,918 | 196,616,537 |

| | | | |
|---|---|---|---|
| 2.3 | **Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр** | **2,605,363,346** | **3,847,769,691** |
| 2.3.1 | Банк, санхүүгийн байгууллагаас байршуулсан харилцах, хадгаламж | 976,901,747 | 1,206,997,927 |
| 2.3.2 | Банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл (хугацаа хэтэрсэн зээлийн дүнг оруулсан) | 1,621,308,558 | 2,628,287,705 |
| 2.3.3 | Эх үүсвэрийн хойшлогдсон төлбөр | (5,577,059) | (4,299,285) |
| 2.3.4 | Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэрт хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг | 12,730,100 | 16,783,344 |
| 2.4 | **Бусад эх үүсвэр** | **816,269,796** | **1,316,964,551** |
| 2.4.1 | Банкнаас гаргасан өрийн бичиг | - | - |
| 2.4.2 | Банкнаас гаргасан үнэт цаас | 666,848,059 | 996,456,798 |
| 2.4.3 | Төслийн зээлийн санхүүжилт | 39,292,368 | 240,257,043 |
| 2.4.4 | Буцаан худалдан авах нөхцөлөөр худалдсан үнэт цаас (репо) | 21,990,771 | - |
| 2.4.5 | Хамтын зээлжүүлэлтийн эх үүсвэр | - | - |
| 2.4.6 | Бусад | 80,680,022 | 75,788,791 |
| 2.4.7 | Бусад эх үүсвэрийн хойшлогдсон төлбөр | - | - |
| 2.4.8 | Бусад эх үүсвэрт хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг | 7,458,576 | 4,461,918 |
| 2.5 | **Дериватив санхүүгийн өр төлбөр** | **70,630,118** | **92,386,360** |
| 2.6 | **Бусад санхүүгийн өр төлбөр** | **139,481,989** | **90,465,018** |
| 2.7 | **Бусад санхүүгийн бус өр төлбөр** | **97,216,480** | **63,619,754** |
| 2.8 | **Хоёрдогч өглөг** | **-** | **-** |
| 2.9 | **Давуу эрхийн хувьцаа (өр төлбөр)** | **-** | **-** |
| 2.10 | **Нийт өр төлбөрийн дүн** | **13,384,383,097** | **16,539,927,305** |
| 3 | **ӨӨРИЙН ХӨРӨНГӨ** | **-** | **-** |
| 3.1 | **Хувь нийлүүлсэн хөрөнгө** | **340,852,905** | **340,852,905** |
| 3.1.1 | Давуу эрхийн хувьцаа | - | - |
| 3.1.2 | Энгийн хувьцаа | 340,852,905 | 340,852,905 |
| 3.2 | **Нэмж төлөгдсөн капитал** | **64,069,779** | **64,069,779** |
| 3.3 | **Халаасны хувьцаа** | **-** | **-** |
| 3.4 | **Дахин үнэлгээний нэмэгдэл** | **143,364,654** | **143,093,248** |
| 3.5 | **Хуримтлагдсан ашиг, алдагдал** | **892,938,857** | **1,021,846,904** |
| 3.6 | **Бусад өөрийн хөрөнгө** | **174,759,392** | **154,236,504** |
| 3.6.1 | Хувьцааны опцион | - | - |
| 3.6.2 | Нөөцийн сан | 494,516 | 494,516 |
| 3.6.3 | Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц | - | - |
| 3.6.4 | Эрсдэлийн сангийн нөөц | 129,398,712 | 100,110,188 |
| 3.6.5 | Нийгмийн хөгжлийн сан | - | - |
| 3.6.6 | Хувьцаанд хөрвөх үнэт цаас (өөрийн хөрөнгө) | - | - |
| 3.6.7 | Хувьцаанд хөрвөх эх үүсвэр (өөрийн хөрөнгө) | - | - |
| 3.6.8 | Борлуулахад бэлэн үнэт цаасны дахин үнэлгээний сан | - | - |
| 3.6.9 | Хейджийн хэрэгслийн дахин үнэлгээний сан | - | - |
| 3.6.10 | Бусад | 44,866,164 | 53,631,800 |
| 3.7 | **Өөрийн хөрөнгийн дүн** | **1,615,985,587** | **1,724,099,341** |
| 4 | **Өр төлбөр ба өөрийн хөрөнгийн дүн** | **15,000,368,684** | **18,264,026,646** |

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ О.ОРХОН

СУХГ-ЫН ЗАХИРАЛ Д.ЭНХТУЯА

**Байгууллагын нэр: Худалдаа хөгжлийн банк**
**Регистр: 2635534**

## ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

/Мянган төгрөг/

| № | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл (2024.12.31) | Эцсийн үлдэгдэл (2025.12.31) |
|---|---|---|---|
| 1 | **Хүүгийн орлого** | **1,085,996,674** | **1,435,726,251** |
| 1.1 | Монголбанкинд байршуулсан хөрөнгийн | 37,798,844 | 16,021,069 |
| 1.2 | Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгийн | 48,189,863 | 33,959,615 |
| 1.3 | Үнэт цаасны | 234,071,424 | 249,672,212 |
| 1.4 | Зээлийн | 765,936,543 | 1,095,290,865 |
| 1.5 | Бусад хүүгийн орлого | 0 | 40,782,490 |
| 2 | **Хүүгийн зардал** | **602,479,107** | **1,008,587,568** |
| 2.1 | Харилцахад төлсөн хүү | 58,066,542 | 46,050,417 |
| 2.2 | Хадгаламжинд төлсөн хүү | 469,211,146 | 682,328,128 |
| 2.3 | Зээлийн хүүгийн зардал | 64,570,979 | 67,679,628 |
| 2.4 | Үнэт цаасны хүүгийн зардал | 8,827,830 | 212,266,127 |
| 2.5 | Бусад хүүгийн зардал | 1,802,610 | 263,269 |
| 3 | **ЦЭВЭР ХҮҮГИЙН ОРЛОГО(1-2)** | **483,517,567** | **427,138,682** |
| 4 | **Эрсдэлийн сангийн зардал** | **-34,362,102** | **111,180,051** |
| 4.1 | Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгийн | 0 | 0 |
| 4.2 | Үнэт цаасны | 0 | 0 |
| 4.3 | Зээлийн | -34,362,102 | 111,180,051 |
| 5 | **Эрсдэлийн сангийн дараах цэвэр орлого [(3)-(4)]** | **517,879,669** | **315,958,631** |
| 6 | **Бусад орлого** | **182,549,241** | **352,899,791** |
| 6.1 | **Хүүгийн бус орлого** | **181,073,020** | **327,958,812** |
| 6.1.1 | Арилжааны орлого | 48,621,463 | 52,484,388 |
| 6.1.2 | Ханш, үнэлгээний тэгшитгэлийн орлого | 18,315,365 | 22,731,339 |
| 6.1.3 | Банкны бүтээгдэхүүнтэй холбоотой үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого | 116,961,225 | 142,793,159 |
| 6.1.4 | Бусад хүүгийн бус орлого | -2,825,033 | 109,949,927 |
| 6.2 | Бусад орлого, олз | 1,476,221 | 24,940,979 |
| 7 | **Бусад зардал** | **312,223,047** | **429,412,526** |
| 7.1 | **Хүүгийн бус зардал** | **297,878,626** | **419,068,474** |
| 7.1.1 | Бусад эрсдэлийн сангийн зардал | 28,910,036 | 23,611,284 |
| 7.1.2 | Арилжааны зардал | 4,524,782 | 5,508,379 |
| 7.1.3 | Ханш, үнэлгээний тэгшитгэлийн зардал | 1,186,163 | 32,482,088 |
| 7.1.4 | Хураамж, шимтгэлийн зардал | 48,601,606 | 67,516,766 |
| 7.1.5 | Үйл ажиллагааны бусад зардал | 214,656,039 | 289,949,957 |
| 7.2 | Бусад зардал, гарз | 14,344,421 | 10,344,052 |
| 8 | **Татварын өмнөх ашиг, алдагдал (5+6-7)** | **388,205,863** | **239,445,896** |
| 9 | Орлогын татварын зардал | 89,570,244 | 38,895,925 |
| 10 | **Татварын дараах ашиг, алдагдал (8-9)** | **298,635,619** | **200,549,971** |
| 11 | Зогсоосон үйл ажиллагааны цэвэр орлого, зардал | 0 | 0 |
| 12 | **Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал (10+11)** | **298,635,619** | **200,549,971** |
| 13 | **Бусад дэлгэрэнгүй орлого** | **9,451,129** | **8,765,637** |
| 13.1 | Үндсэн хөрөнгө ба биет бус хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансны өсөлт, бууралт | 0 | 0 |
| 13.2 | Борлуулахад бэлэн үнэт цаасны дахин үнэлгээний өсөлт, бууралт | 9,451,129 | 8,765,637 |
| 13.3 | Ханш, үнэлгээний тэгшитгэлийн сангийн өсөлт, бууралт | 0 | 0 |
| 13.4 | Эрсдэлийн сангийн нөөцийн өсөлт, бууралт | 0 | 0 |
| 13.5 | Бусад | 0 | 0 |
| 14 | **Тайлант хугацааны нийт дэлгэрэнгүй орлогын дүн (12+13)** | **308,086,748** | **209,315,608** |

| № | Тэнцлийн гадуурх данс | /Мянган төгрөг/ |
|---|---|---|
| 1 | Зээл, зээлтэй адилтгах хөрөнгөд хамаарах үүрэг (цэвэр дүнгээр) | **1,534,878,776** |

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ О.ОРХОН

СХУГ-ЫН ЗАХИРАЛ Д.ЭНХТУЯА

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХК
TRADE AND DEVELOPMENT BANK JSC

Байгууллагын нэр: Худалдаа хөгжлийн банк
Регистр: 2635534

## МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Мянган төгрөг/

| № | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл (2024.12.31) | Эцсийн үлдэгдэл (2025.12.31) |
|---|---|---|---|
| 1 | **Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | *** | *** |
| 1.1 | Орлогын татварын өмнөх ашиг (алдагдал) | 388,205,863 | 239,445,897 |
| 1.2 | **Орлого, зардлын тохируулга** | **(654,728,807)** | **(364,756,292)** |
| 1.2.1 | Эрсдэлийн сангийн зардал (+) | (183,563,185) | 44,749,308 |
| 1.2.2 | Элэгдэл, хорогдлын зардал (+) | 12,351,946 | 17,633,083 |
| 1.2.3 | Ханш, үнэлгээний тэгшитгэлийн орлого (-), зардал (+) (Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөөс бусад) | 0 | 0 |
| 1.2.4 | Хуримтлуулсан хүүгийн орлого (-) | (1,085,996,675) | (1,435,726,251) |
| 1.2.5 | Хуримтлуулсан хүүгийн зардал (+) | 602,479,107 | 1,008,587,568 |
| 1.2.6 | Хөрөнгө данснаас хассаны олз (-), гарз (+) | 0 | 0 |
| 1.2.7 | Бусад олз (-), гарз (+) | 0 | 0 |
| 1.3 | **Хөрөнгө, өр төлбөрийн өөрчлөлтийн тохируулга** | **(908,130,091)** | **(1,149,282,145)** |
| 1.3.1 | Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгийн өсөлт (-), бууралт (+) | (1,706,939,607) | (1,865,553,218) |
| 1.3.2 | Арилжааны үнэт цаасны өсөлт (-), бууралт (+) | 0 | 0 |
| 1.3.3 | Зээлийн өсөлт (-), бууралт (+) | (1,244,436,501) | (1,846,166,036) |
| 1.3.4 | Бусад санхүүгийн хөрөнгийн өсөлт (-), бууралт (+) | 171,053,772 | 60,281,166 |
| 1.3.5 | Бусад санхүүгийн бус хөрөнгийн өсөлт (-), бууралт (+) | (213,270,904) | (121,019,392) |
| 1.3.6 | Харилцах, хадгаламжийн өсөлт (+), бууралт (-) | 1,107,925,062 | 1,431,589,522 |
| 1.3.7 | Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэрийн өсөлт (+), бууралт (-) | 1,037,924,769 | 1,187,049,831 |
| 1.3.8 | Бусад санхүүгийн өр төлбөрийн өсөлт (+), бууралт (-) | (113,605,252) | 29,961,614 |
| 1.3.9 | Бусад санхүүгийн бус өр төлбөрийн өсөлт (+), бууралт (-) | 53,218,570 | (25,425,633) |
| 1.4 | **Бусад тохируулга** | **437,755,910** | **379,831,934** |
| 1.4.1 | Авсан хүү (+) | 1,116,782,467 | 1,386,355,104 |
| 1.4.2 | Төлсөн хүү (-) | (589,456,313) | (967,627,244) |
| 1.4.3 | Орлогын татварын төлөлт (-) | (89,570,244) | (38,895,926) |
| 1.4.4 | Эрсдэлийн сангаас хаасан зээл, авлага (-) | 0 | 0 |
| 1.4.5 | | 0 | 0 |
| 1.5 | **Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **(736,897,125)** | **(894,760,607)** |
| 2 | **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | *** | *** |
| 2.1 | **Мөнгөн орлогын дүн (+)** | **1,637,282,315** | **2,979,769,589** |
| 2.1.1 | Үндсэн хөрөнгө борлуулсны орлого | 96,240,769 | 48,332,758 |
| 2.1.2 | Биет бус хөрөнгө борлуулсны орлого | 3,124,412 | 1,802,813 |
| 2.1.3 | Хөрөнгө оруулалтын зориулалттай хөрөнгө борлуулсны орлого | 2,478,546 | 0 |
| 2.1.4 | Охин компани, хараат компани, хамтын хяналттай аж ахуйн нэгжид оруулсан хөрөнгө оруулалт борлуулсны орлого | 5,031,978 | 5,031,979 |
| 2.1.5 | Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого | 0 | 0 |
| 2.1.6 | Зээл ба авлага гэж ангилан хорогдуулсан өртгөөр бүртгэсэн хөрөнгө оруулалт борлуулсны орлого | 0 | 0 |
| 2.1.7 | Борлуулахад бэлэн үнэт цаас борлуулсны орлого | 884,528,264 | 2,664,279,113 |
| 2.1.8 | Хугацааны эцэс хүртэл эзэмших үнэт цаас борлуулсны орлого | 423,918,804 | 434,084 |

| | | | |
|---|---|---|---|
| 2.1.9 | Хүлээн авсан ногдол ашиг | 0 | 0 |
| 2.1.10 | Бусад мөнгөн орлого | 221,959,542 | 259,888,841 |
| 2.2 | **Мөнгөн зарлагын дүн (-)** | **(1,763,027,858)** | **(2,910,044,096)** |
| 2.2.1 | Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | 154,293,824 | 62,199,313 |
| 2.2.2 | Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | 23,453,186 | 5,511,559 |
| 2.2.3 | Хөрөнгө оруулалтын зориулалттай хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | 23,989,866 | 43,433,296 |
| 2.2.4 | Охин компани, хараат компани, хамтын хяналттай аж ахуйн нэгжид оруулсан хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн | 4,271,538 | 1,605,748 |
| 2.2.5 | Зээл ба авлага гэж ангилан хорогдуулсан өртгөөр бүртгэсэн хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн | 0 | 0 |
| 2.2.6 | Борлуулахад бэлэн үнэт цаас олж эзэмшихэд төлсөн | 1,402,764,109 | 2,647,637,800 |
| 2.2.7 | Хугацааны эцэс хүртэл эзэмших үнэт цаас олж эзэмшихэд төлсөн | 16,409,182 | 6,164,192 |
| 2.2.8 | Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | 0 | 0 |
| 2.2.9 | Бусад мөнгөн зарлага | 137,846,153 | 143,492,189 |
| 2.3 | **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **(125,745,543)** | **69,725,493** |
| 3 | **Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | *** | *** |
| 3.1 | **Мөнгөн орлогын дүн (+)** | **5,973,424,391** | **6,396,878,276** |
| 3.1.1 | Бусад эх үүсвэр татаж хүлээн авсан | 5,452,632,480 | 4,377,510,420 |
| 3.1.2 | Хоёрдогч өглөгөөс хүлээн авсан | 0 | 0 |
| 3.1.3 | Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан | 0 | 0 |
| 3.1.4 | Төрөл бүрийн хандив | 0 | 0 |
| 3.1.5 | Бусад | 520,791,911 | 2,019,367,856 |
| 3.2 | **Мөнгөн зарлагын дүн (-)** | **(5,405,692,459)** | **(6,013,554,895)** |
| 3.2.1 | Бусад эх үүсвэрт төлсөн | 4,865,482,618 | 4,040,509,616 |
| 3.2.2 | Хоёрдогч өглөгт төлсөн | 0 | 0 |
| 3.2.3 | Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн | 0 | 0 |
| 3.2.4 | Хувьцаа буцаан худалдан авахад төлсөн | 0 | 0 |
| 3.2.5 | Төлсөн ногдол ашиг | 104,541,515 | 101,201,854 |
| 3.2.6 | Бусад | 435,668,326 | 1,871,843,424 |
| 3.3 | **Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **567,731,932** | **383,323,381** |
| 4 | Валютын ханшийн зөрүү | 0 | 0 |
| 5 | **Бүх цэвэр мөнгөн гүйлгээ** | **(294,910,736)** | **(441,711,732)** |
| 6 | **Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **3,867,167,489** | **3,572,256,753** |
| 7 | **Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **3,572,256,753** | **3,130,545,021** |

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ О.ОРХОН

СУХГ-ЫН ЗАХИРАЛ Д.ЭНХТУЯА

**Байгууллагын нэр: Худалдаа хөгжлийн банк**
**Регистр: 2635534**

## ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/Мянган төгрөг/

| № | Үзүүлэлт | Хувь нийлүүлсэн хөрөнгө | Нэмж төлөгдсөн капитал | Халаасны хувьцаа | Дахин үнэлгээний нэмэгдэл | Бусад өөрийн хөрөнгө | Хуримт-лагдсан ашиг | Нийт Дүн |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | **2023 оны 12-р сарын 31-ний өдрийн үлдэгдэл** | **340,852,905** | **64,069,779** | **0** | **143,479,413** | **170,688,278** | **689,288,519** | **1,408,378,894** |
| 1 | Бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| 2 | **Залруулсан үлдэгдэл** | **340,852,905** | **64,069,779** | **0** | **143,479,413** | **170,688,278** | **689,288,519** | **1,408,378,894** |
| 3 | Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал | 0 | 0 | 0 | 0 | 0 | 298,635,621 | 298,635,621 |
| 4 | Бусад дэлгэрэнгүй орлого | 0 | 0 | 0 | 0 | 9,451,129 | 0 | 9,451,129 |
| 5 | Өмчид гарсан өөрчлөлт | 0 | 0 | 0 | 0 | -5,380,015 | 7,375,972 | 1,995,957 |
| 6 | Хуваарилсан ногдол ашиг | 0 | 0 | 0 | 0 | 0 | -104,541,515 | -104,541,515 |
| 7 | Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн | 0 | 0 | 0 | -114,759 | 0 | 2,180,261 | 2,065,502 |
| | **2024 оны 12-р сарын 31-ний өдрийн үлдэгдэл** | **340,852,905** | **64,069,779** | **0** | **143,364,654** | **174,759,391** | **892,938,857** | **1,615,985,587** |
| 1 | Бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| 2 | **Залруулсан үлдэгдэл** | **340,852,905** | **64,069,779** | **0** | **143,364,654** | **174,759,391** | **892,938,857** | **1,615,985,587** |
| 3 | Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал | 0 | 0 | 0 | 0 | 0 | 200,549,971 | 200,549,971 |
| 4 | Бусад дэлгэрэнгүй орлого | 0 | 0 | 0 | 0 | 8,765,637 | 0 | 8,765,637 |
| 5 | Өмчид гарсан өөрчлөлт | 0 | 0 | 0 | 0 | -29,288,524 | 29,288,524 | 0 |
| 6 | Хуваарилсан ногдол ашиг | 0 | 0 | 0 | 0 | 0 | -101,201,854 | -101,201,854 |
| 7 | Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн | 0 | 0 | 0 | -271,406 | 0 | 271,406 | 0 |
| | **2025 оны 12-р сарын 31-ны өдрийн үлдэгдэл** | **340,852,905** | **64,069,779** | **0** | **143,093,248** | **154,236,504** | **1,021,846,904** | **1,724,099,341** |

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХК
TRADE AND DEVELOPMENT BANK JSC
9023080616
2635534 АТА 10559

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ О.ОРХОН

СУХГ-ЫН ЗАХИРАЛ Д.ЭНХТУЯА

TDB
ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК



# КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

# КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

Худалдаа, хөгжлийн банк ХК нь зохицуулагч байгууллагаас баталсан зохистой засаглалын зарчмуудыг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгон, хөрөнгө оруулагч, харилцагч болон бусад оролцогч талуудын эрх ашгийг хамгаалах, урт хугацаанд үнэ цэн бүтээх, банкны тогтвортой байдлыг хангах, санхүүгийн эрсдэлийг бууруулах үүднээс засаглалын тогтолцоог сайжруулах, олон улсын сайн туршлагыг нутагшуулан, ТУЗ болон банкны бүхий л нэгжийг хамарсан банкны стратеги төлөвлөгөө, байгууллагын бүтэц, бодлогыг тодорхойлон, оролцогч талуудын хамтын ажиллагааг нэмэгдүүлэхэд өндөр ач холбогдол өгч ажилладаг.




# ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ




НИЙТ ГАРГАСАН ХУВЬЦААНЫ ТОО

**50,600,967**

НИЙТ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ

**2,829**

*2025/12/31-ний өдрийн байдлаар*

# ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт Банкны эрх барих дээд байгууллага нь Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх) байна. ТУЗ нь олон талт ур чадвар, мэдлэг, туршлага, ашиг сонирхлын зөрчил, хараат бус байдал, хүйсийн тэнцвэр зэргийг зохистойгоор хангасан гишүүдийн бүрэлдэхүүнтэйгээр бүтээлч, үр дүнтэй бүтэцтэй байхыг зорьж ажилладаг.







***<u>ТУЗ-ийн дагаж мөрдөх Хууль, тогтоомж журам, заавар</u>***

- Компанийн тухай хууль
- Банкны тухай хууль
- ХХБ ХК-ийн дүрэм
- ТУЗ-ийн үйл ажиллагааны журам
- Үнэт цаасны зах зээлийн тухай
- Банкны үйл ажиллагаанд хийх хязгаарлалтыг тооцох, хангах, тайлагнах, хяналт тавих журам
- Банкны зохистой засаглалын зарчмын хэрэгжилтийн хяналт шалгалтын журам
- Банкны төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх журам
- Компанийн засаглалын кодекс
- Үнэт цаасны зах зээл дэх дотоод мэдээллийн жагсаалт, түүнийг мэдээлэх журам
- Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэж журам
- Үнэт цаас гаргагчаас олон нийтэд хүргэх мэдээллийн журам
- Ногдол ашиг тараах ажиллагааг нарийвчлан тогтоох СЗХ-ны тогтоол
- **Дотоод журам, заавар**

# Төлөөлөн удирдах зөвлөлийн Гишүүд



**РАНДОЛФ КОППА**
ТУЗ-ийн дарга



**Д.ЭРДЭНЭБИЛЭГ**
ТУЗ-ийн гишүүн



**Д.ЯНЖМАА**
ТУЗ-ийн гишүүн



**Д.ХҮРЭЛБААТАР**
ТУЗ-ийн гишүүн



**А.ЭНХМЭНД**
ТУЗ-ийн гишүүн



**Д.ОТГОНБИЛЭГ**
ТУЗ-ийн гишүүн



**Ж.ДЭЛГЭРСАЙХАН**
ТУЗ-ийн хараат бус гишүүн
2025.10.28 хүртэл



**Ж.БОЛОРМАА**
ТУЗ-ийн хараат бус гишүүн



**Г.БАТЖАРГАЛ**
ТУЗ-ийн хараат бус гишүүн

Монголбанк болон Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхэлдэг, олон нийтээс хөрөнгө татан төвлөрүүлсэн нээлттэй хувьцаат компани болохын хувьд ТУЗ нь хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас баталсан дүрэм, журам, зааврын хүрээнд ажиллаж байна.

2025 онд Төлөөлөн удирдах зөвлөл 18 удаагийн хурлаар дараах чиглэлүүдээр 71 асуудлыг хэлэлцэж шийдвэрлэн 64 тогтоол гаргасан ба хурлын дундаж ирц 77.8 хувьтай байна.

Түүнчлэн тайлант хугацаанд засаглалтай холбоотой дараах бодлого, заавар, журмыг баталж, нэмэлт өөрчлөлт оруулж ажилласан байна.

- Худалдаа, хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн харьяа нэгжүүдийн ажилтнуудын чадамжийн үнэлгээний журам;
- ХХБ-ны холбогдох этгээдийн мэдээллийн сангийн журам;
- ТУЗ-ийн дэргэдэх Тогтвортой хөгжлийн хорооны ажиллах журам;
- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Худалдаа, хөгжлийн банкны журам.

# ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ХОРОО

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК

**Хараат бус гишүүнээр даргалуулсан байх ба бүрэлдэхүүний 2/3-оос доошгүй хараат бус гишүүнтэй ажилладаг** (Аудитын хороо, Эрсдэлийн удирдлагын хороо, Цалин урамшууллын болон нэр дэвшүүлэх хороо)

## АУДИТЫН ХОРОО

Аудитын хороо нь Банкны засаглал, хууль тогтоомжийн хэрэгжилт, ёс зүйн хэм хэмжээ, санхүүгийн тайлагнал, дотоод хяналтын тогтолцоо, хөндлөнгийн болон дотоод аудитын үйл ажиллагаанд системтэйгээр дүгнэлт өгөх, банкны хувьцаа эзэмшигчид, ТУЗ болон бусад оролцогч талуудад үнэн зөв бодит мэдээллийг хүргэх замаар байгууллагын удирдлага, зохион байгуулалтын бүх түвшинд сайн засаглалын тогтолцоог бэхжүүлэх зорилготой.

Хорооны дарга:
Ж.Дэлгэрсайхан/2025.10.28 хүртэл/
Гишүүд:
Ж.Болормаа
Д.Отгонбилэг

## ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ХОРОО

ТУЗ-ийн үйл ажиллагаанд Монгол улсын хууль журам, зохицуулагч болон олон улсын байгууллагууд, Базелийн хорооноос тогтоосон зөвлөмж, стандарт, эрсдэлийн удирдлагын тогтолцоо, бодлого зэргийн хэрэгжилтийг хянах, чиглэл өгөхөөд дэмжлэг үзүүлэх чиглэлийн хороо юм. Үйл ажиллагааны өргөн цар хүрээг хамарч хараат бус байдлаар эрсдэлээс хамгаалах, зах зээл, үйл ажиллагааны эрсдэл болон комплайнсын хэрэгжилтэнд баталгаажуулалт хийж, үнэлэлт дүгнэлт, зөвлөмж өгч ажилладаг.

Хорооны дарга:
Г.Батжаргал /2025.07.01-ээс эхлэн/
Гишүүд:
Рандолф Коппа
Ж.Дэлгэрсайхан/2025.10.28 хүртэл/

## ЦАЛИН УРАМШУУЛЛЫН БОЛОН НЭР ДЭВШҮҮЛЭХ ХОРОО

ТУЗ-ийн хяналт, удирдлагын үүргээ үр дүнтэй, ашигтайгаар хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, ТУЗ-ийн бүтэц бүрэлдэхүүнд эргэн хяналт хийх, гишүүдийг сонгон шалгаруулах, үнэлэх, Гүйцэтгэх удирдлага болон удирдлагын түвшний захирлуудыг нэр дэвшүүлэх, ТУЗ-ийн үйл ажиллагааг дүгнэж тайлагнах, тэдгээрийн цалин хөлс урамшууллын хэмжээ, бодлогыг тодорхойлох, банкны бүтэц, зохион байгуулалт, засаглалыг хөгжүүлэх чиглэл өгөх зэрэг эрх үүрэгтэй хороо болно.

Хорооны дарга:
Ж.Болормаа
Гишүүд:
Д.Янжмаа
Г.Батжаргал /2025.07.01-ээс эхлэн/

## ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ХОРОО

Тогтвортой хөгжлийн бодлогоор банкны засаглал, стратеги, зорилго, зорилтыг тодорхойлох, дотоодын болон олон улсын сайн туршлагыг өөрийн төдийгүй оролцогч талуудын үйл ажиллагаанд нутагшуулах, ногоон болон тогтвортой бизнесийн зарчмууд, хамтын ажиллагааг дэмжих зорилгоор байгуулагдсан болно. Байгаль, орчин нийгэм, засаглалын удирдлага, бодлогыг хэрэгжүүлэх замаар банкныхаа үйл ажиллагааны бүхий л түвшинд төдийгүй Монгол улсдаа үлгэрлэн манлайлах зарчмыг баримтлан ажилладаг хороо болно.

Хорооны дарга:
Рандолф Коппа
Гишүүд:
Н.Сэргэлэн
Г.Чимидбалдир
Д.Халиун

КТХ: ТУЗ нь шаардлагатай гэж үзвэл тодорхой асуудал эрхэлсэн байнгын болон түр хороог байгуулж болно.
Хороод бүр үйл ажиллагааны журамтай байх бөгөөд ТУЗ-д тайлагнах үүрэгтэй

# ИЛ ТОД БАЙДАЛ

- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2025 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр амжилттай зохион байгуулж, дараах асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлүүлсэн:
  - Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлт;
  - Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох
  - Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн зардлыг батлах.

- Тайланд хугацаанд дараах тайлангуудыг гаргасан. Үүнд:
  - Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар батлагдсан Банкны зохистой засаглалын зарчмын хэрэгжилтийн хяналт шалгалтын журмын дагуу зохистой засаглалын зарчмын хэрэгжилтийн тайлан;
  - Санхүүгийн зохицуулах хорооны Компанийн засаглалын кодекст заасны дагуу ХХБ-ны 2024 оны Засаглалын хэрэгжилтийн тайлан;
  - Байгаль орчин, нийгэм засаглалын тайлан;
  - 2025 оны үйл ажиллагааны тайлан;
  - 2025 оны санхүүгийн аудитлагдсан тайлан;
  - 2025 оны ТУЗ-ийн үйл ажиллагааны тайлан;
  - 2025 оны ТУЗ-ийн дэргэдэх хороодуудын ажлын тайлан;
  - ХХБ ХК-аас 2025 онд бусад оролцогч талуудтай хамтран ажилласан талаар тайлан;
  - ТУЗ-ийн хараат бус гишүүдийн хагас жил тутмын ажлын тайлан;

# ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА

ХХБ ХК-ийн дүрмэнд Банкны гүйцэтгэх удирдлагыг ТУЗ-өөс томилогдсон Гүйцэтгэх захирал хэрэгжүүлэхээр заасан бөгөөд ноён О.Орхон 2016 оны 1 сараас тус банкны Гүйцэтгэх захирлаар ажиллаж байна. ТУЗ-ийн гишүүдээс гадна дараах албан тушаалтнуудыг Банкны эрх бүхий албан тушаалтан байхаар дүрмэнд заасан ба Дижитал шилжилт хариуцсан Гүйцэтгэх захирлын тэргүүн орлогч шинээр томилогдсон байна

| № | Албан тушаал | Нэр |
|---|---|---|
| 1 | ТУЗ-ийн нарийн бичгийн дарга | Н.Нямсүрэн |
| 2 | Гүйцэтгэх захирал | О.Орхон |
| 3 | Ерөнхийлөгч | |
| 4 | Гүйцэтгэх захирлын тэргүүн орлогч | А.Энхмэнд |
| 5 | Гүйцэтгэх захирлын тэргүүн орлогч | О.Банзрагч |
| 6 | Гүйцэтгэх захирлын тэргүүн орлогч | Дэ Юүн Мартэйн Кристофэл |
| 7 | Дотоод аудитын газрын захирал | Ч.Лхагвасүрэн |
| 8 | Санхүүгийн, удирдлага, хяналтын газрын захирал | Д.Энхтуяа |

## ХУДАЛДАА, ХӨГЖЛИЙН БАНК ХК-ИЙН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ӨГСӨН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДҮГНЭЛТ

Монголын банкны салбар 2024 онд өмнөх оны томоохон өөрчлөлт, шинэчлэлтүүдийн үр нөлөөг бататган, цаашдын тогтвортой хөгжлийн суурийг бэхжүүлэхэд анхаарсан жил байлаа. Худалдаа, хөгжлийн банк (ХХБ) нь нээлттэй хувьцаат компани болсон статусаа ашиглан, засаглал, ил тод байдлаа улам сайжруулж, зах зээлд өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа идэвхтэй явуулсаар байна. Банкны салбар ерөнхийдөө өсөлтөө хадгалахын зэрэгцээ, дижитал шилжилт, эрсдэлийн удирдлагыг боловсронгуй болгох зэрэгт түлхүү анхаарсан нь 2024 оны онцлог байв.

ХХБ нь нээлттэй хувьцаат компани болсноор бэхэжсэн Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)-ийн бүрэлдэхүүн 2024 онд банкны стратегийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэв. Өргөтгөсөн, олон талт ур чадвартай ТУЗ нь банкны бизнесийн тасралтгүй өсөлтийг дэмжих, эрсдэлийн удирдлагын оновчтой тогтолцоог хэвшүүлэх, дотоодын болон олон улсын шилдэг туршлага, стандартыг үйл ажиллагаанд нэвтрүүлэхэд чиглэсэн стратегийн удирдамж, зөвлөмжөөр тогтмол хангаж ажиллалаа. ТУЗ нь 2024 оны турш Компанийн тухай хууль, Банкны тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж, Банкны зохистой засаглалын зарчмууд болон ХХБ-ны дүрмийг үйл ажиллагааныхаа үндэс болгон, ТУЗ болон түүний дэргэдэх хороодын тогтоол, шийдвэрээр дамжуулан банкны үйл ажиллагааг чиглүүлж, хувьцаа эзэмшигчид болон бусад оролцогч талуудын эрх ашгийг дээдлэн, тэдний үнэ цэнийг өсгөхөд онцгой анхаарал хандуулав.

Банкны 2024 оны үйл ажиллагаа болон аудитлагдсан санхүүгийн тайланд өгөх ТУЗ-ийн дүгнэлт нь ХХБ-ны урт болон дунд хугацааны стратегийн хэрэгжилт, тухайн жилийн батлагдсан санхүүгийн болон үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтэд ТУЗ-ийн гишүүдийн хийсэн хараат бус, бодит үнэлгээнд суурилсан болно.

2024 онд ХХБ-ны Гүйцэтгэх удирдлагын баг болон нийт ажилтнууд ТУЗ-өөс баталсан стратегийн чиглэлийн дагуу банкны урт хугацааны зорилтууд болох:

- Харилцагч төвтэй байдлаа улам гүнзгийрүүлэх,
- Олон улсын зах зээл дэх байр суурьа бэхжүүлэх,
- Технологийн дэвшилд суурилсан, шинэлэг үйлчилгээ бүхий платформ банк болох алсын харааг хэрэгжүүлэхэд хүчин чармайлт гарган ажиллаа. Эдгээр хүчин чармайлтын үр дүнд банкны актив, ашигт ажиллагааг нэмэгдүүлэх, зах зээлд эзлэх байр суурьа бэхжүүлэх чиглэлээр төлөвлөгөөт зорилтуудыг хангаан биелүүлэхээр хичээнгүйлэн ажилласан гэдэгт итгэлтэй байна.

2024 он нь стратегийн зорилтуудаа амжилттай ахиулж, зах зээл дэх манлайлал, олон улсын тавцан дахь нэр хүндээ улам бататган, инноваци, тогтвортой хөгжлийн чиглэлээр бодитой үр дүнд хүрсэн онцгой жил байлаа. Банкны урт хугацааны стратегийн гурван тулгуур чиглэлийн хүрээнд Гүйцэтгэх удирдлага болон нийт ажилтнуудын хүчин чармайлтаар 2024 онд дараах томоохон амжилтад хамтын хүчээр бид хүрлээ.

**Харилцагч төвтэй банк болох зорилтын хүрээнд:**

Банкны бүх үйл ажиллагааны төвд харилцагчийг тавьж, тэдний хэрэгцээ шаардлагад нийцсэн, орчин үеийн, хүртээмжтэй, найдвартай үйлчилгээг хүргэхэд онцгой анхаарал хандуулж, харилцагчийн туршлагыг тасралтгүй сайжруулж, ажиллалаа. Харилцагчдадаа дэлхийн жишигт нийцсэн, хялбар, аюулгүй төлбөрийн шийдлийг санал болгох зорилгоор ApplePay үйлчилгээг Монгол Улсад анхлан амжилттай нэвтрүүлж, дижитал төлбөр тооцооны шинэ боломжийг нээлээ. Харилцагчийн картын болон хувийн мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг олон улсын дээд түвшний стандартад нийцүүлэн ажиллаж байна. Харилцагчдад үйлчлүүлэх таатай, орчин үеийн орчин нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор үндэсний шилдэг компаниудын нэг A1 Architects-тэй хамтран банкны салбаруудын дотоод интерьер, тохижилтыг шинэчлэх ажлыг эхлүүлж, үйлчилгээний чанарт бодит хөрөнгө оруулалт хийлээ.

**Олон улсын банк болох зорилтын хүрээнд:**

ХХБ нь олон улсын санхүүгийн зах зээлд Монгол Улсын болон өөрийн банкны нэр хүндийг өсгөх, дэлхийн жишигт нийцсэн үйл ажиллагаа явуулах, гадаад харилцаа, хамтын ажиллагаагаа өргөжүүлэх чиглэлээр 2024 онд томоохон алхмуудыг хийлээ. АНУ-ын Bank of New York Mellon-той тогтоосон ам.долларын ностро дансны харилцаагаа бататгаж, Монгол Улсыг дэлхийн ам.долларын төлбөрийн системд найдвартай, тасралтгүй холбох үүргээ амжилттай гүйцэтгэв. Түүхэн амжилт болгож, Монголын банк санхүүгийн байгууллагаас анх удаа АНУ-ын Засгийн газрын агентлаг болох Олон Улсын Хөгжлийн Санхүүжилтийн Корпорац (DFC)-аас шууд урт хугацааны санхүүжилт татсан нь Монгол Улсын бичил, жижиг, дунд үйлдвэрлэл, эмэгтэй бизнес эрхлэгчдийн өсөлт болон уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх үйлсэд бодитой хувь нэмэр оруулах чухал эх үүсвэр болов. Мөн Австри Улсын Венийн хөрөнгийн бирж дээр олон улсын мэргэжлийн хөрөнгө оруулагчдад зориулан Монгол Улсаас анх удаа Нийгмийн болон Ногоон бондыг амжилттай гаргаж, дэлхийн топ 10-т багтдаг Ассет Менежмент компаниас хөрөнгө оруулалт татсан нь олон улсын тогтвортой санхүүжилтийн зах зээлд нэвтрэх шинэ гарцыг нээлээ. Эдгээр амжилтууд нь банкны санхүүгийн тогтвортой байдал, зөв засаглалын илрэл болж, олон улсын зэрэглэл тогтоогч Moody's агентлагаас ХХБ-ны зээлжих зэрэглэлийг B2 “Тогтвортой” түвшинд ахиулахад эерэгээр нөлөөлөв.

**Платформ банк болох зорилтын хүрээнд:**

Технологийн дэвшлийг үйл ажиллагаандаа үр дүнтэй нэвтрүүлж, банкны үйлчилгээний хүртээмж, үр ашиг, найдвартай байдлыг нэмэгдүүлэхэд чухал ахиц дэвшил гаргалаа. Төлбөрийн картын аюулгүй байдлын олон улсын PCI DSS 4.0 стандартыг амжилттай хангаж, 8 дахь жилдээ харилцагчийн мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг ханган ажиллаж байна. Банкны үйлчилгээг газарзүйн байршлаас үл хамааран хүргэх, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор Агент банкны үйлчилгээг амжилттай нэвтрүүлж, банкны үйлчилгээг иргэдэд илүү ойртуулсан шинэлэг сувгийг бий болгов. Харилцагч, олон нийтэд зориулсан мэдээллийн гол суваг болох банкны вебсайтыг Канад улсын Image X компанитай хамтран орчин үеийн шаардлагад нийцүүлэн шинэчилж, дижитал орчин дахь хэрэглэгчийн туршлагыг сайжруулав.

**Тогтвортой хөгжил ба хамтын үнэ цэн бүтээх:**

ХХБ нь тогтвортой хөгжлийн зорилтуудыг үйл ажиллагаандаа тууштай хэрэгжүүлж, эдийн засгийн тулгуур хүч болсон жижиг, дунд бизнес (ЖДБ)-ийг идэвхтэй дэмжлээ. Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг (GIZ)-тэй хамтран ЖДБ-ийг дэмжих "SFME" төслийг хэрэгжүүлэх гэрээ байгуулж, Дижитал Кредит ХХК-тай хамтын ажиллагаа эхлүүлэв. Түүнчлэн, Ханбогдын Хөгжлийн Хурдасгуур Оюу Толгойн сан, Даян дэлхийн ногоон хөгжлийн институт (GGGI), Нийслэлийн ЖДҮҮ-г Дэмжих Төв, Зээлийн Батлан Даалтын Сан зэрэг байгууллагуудтай хамтран ажиллах санамж бичиг, гэрээ хэлэлцээрүүдийг байгуулж, бүс нутгийн ногоон хөгжил, ЖДБ-ийн санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд чухал алхмууд хийлээ. Анх удаа эмэгтэй бизнес эрхлэгчдэд зориулсан "BE LADY" форумыг амжилттай зохион байгуулж, жендэрийн тэгш байдлыг дэмжих чиглэлээр хийсэн ажлуудаараа Тогтвортой Санхүүжилтийн Холбоооос "Жендерийн Манлай Байгууллага"-аар шалгарав. Мөн уламжлал болгон зохион байгуулдаг “Trade Finance Forum 2024” арга хэмжээ, EuroChamber Mongolia-ийн арга хэмжээ, UN-Day 2024 зэрэгт дэмжлэг үзүүлж, идэвхтэй оролцож ажиллаа.

**Ажилтнуудын үнэлэмж, байгууллагын соёл:**

Банкны амжилтын түлхүүр, хамгийн үнэ цэнтэй капитал болох нийт ажилтнуудынхаа уйгагүй хичээл зүтгэл, байгууллагын өсөлтөд оруулсан бодит хувь нэмрийг өндрөөр үнэлж, авьяаслаг боловсон хүчнээ тогтвортой ажиллуулан, урамшуулах бодлогынхоо хүрээнд гүйцэтгэх удирдлагаас бусад ажилтнуудын бүтээмжийн цалинг 25 хүртэлх хувиар нэмэгдүүлэх чухал шийдвэрийг гаргасан нь бидний зүгээс ажилтнуудаа талархал илэрхийлж буйн нэгээхэн хэлбэр гэж үзэж байна.

Төлөөлөн удирдах зөвлөл нь Худалдаа, хөгжлийн банк 2024 онд өөрийн стратегийн гурван үндсэн чиглэлийн хүрээнд тодорхой зорилтуудыг амжилттай хэрэгжүүлж, олон улсын тавцанд байр сууриа бэхжүүлэн, харилцагч төвтэй соёлыг гүнзгийрүүлж, технологийн шинэчлэлийг нэвтрүүлснээр тогтвортой хөгжил, нийгмийн хариуцлагын манлайллаа бататгаж, бүх оролцогч талуудынхаа өмнө хүлээсэн үүргээ нэр төртэй биелүүлэн, үнэ цэнийг нэмэгдүүлсэн онцгой үр дүнтэй жил байлаа хэмээн дүгнэж байна. 2024 онд бий болгосон эдгээр бодит амжилтууд нь банкны цаашдын тогтвортой өсөлт, хөгжил дэвшлийн бат бэх үндэс суурь болж, ирээдүйн улам их амжилтад хүрэхэд түлхэц үзүүлнэ гэдэгт итгэлтэй байна.

**Санхүүгийн үзүүлэлт**

2024 онд санхүүгийн үйл ажиллагааны хувьд онцгой амжилт гаргаж, цэвэр ашгаа өмнөх оноос 97.5 хувиар өсгөн 298.6 тэрбум төгрөгт хүргэлээ. Энэхүү өндөр өсөлтөд банкны үндсэн орлогын сувгууд болох хүүгийн орлого 42.0 хувиар, шимтгэл хураамжийн орлого 24.8 хувиар тус тус эрчимтэй нэмэгдсэнээс гадна, зээлийн багцын чанарыг сайжруулах чиглэлээр авсан арга хэмжээний үр дүнд чанаргүй зээлийн хэмжээг 54.3 хувиар мэдэгдэхүйц бууруулж ажиллаж чадсан нь голлон нөлөөлөв. Мөн банкны 3 сегмент болох байгууллага, ЖДБ, иргэдийн сегментийн зээлийн багцуудын нийт багцад эзлэх хувийг 50/20/30 хувь болгох, эрсдэлээр жигнэсэн активын эзлэх хувийг 60/18/22 хувь болгох зорилтдоо хүрснээр төвлөрлийн эрсдэлийг бууруулж цаашдын бизнесийн өсөлтийн стратегийг хангаж ажиллаа.

Банкны нийт актив 23.3 хувиар өсөж, 15.0 их наяд төгрөгт хүрсэн нь тогтвортой өсөлтийг харуулж байна. Үүний зэрэгцээ, банкны санхүүгийн чадавх, тогтвортой байдлын илэрхийлэл болсон өөрийн хөрөнгийн хэмжээ 14.7 хувиар өсөж, 1.6 их наяд төгрөгт хүрсэн нь цаашдын өсөлт, хөгжлийн бат бэх суурийг улам бэхжүүллээ. Банкны зүгээс тогтвортой өсөлтийг хадгалахын зэрэгцээ эрсдэлийг оновчтой удирдах зорилтын хүрээнд төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцааг 49.5 хувиар найдвартай түвшинд барьж санхүүгийн тогтвортой байдлыг ханган ажиллалаа.

ХХБ нь 2024 оны эцсийн байдлаар Монгол Улсын банкны салбарын нийт активын 21.3 хувь (15.0 их наяд төгрөгийн активаараа), нийт зээлийн 19.2 хувь, нийт татан төвлөрүүлсэн хөрөнгийн 21.1 хувь, нийт ашгийн 11.9 хувийг дангаараа бүрдүүлсэн нь банкны системийн нөлөө бүхий, тэргүүлэгч банкны байр сууриа тодотгон харуулсаар байна. Эдгээр үзүүлэлтүүдээрээ ХХБ нь Монгол Улсын эдийн засаг, банкны салбарт эзлэх тэргүүлэх байр сууриа бататгаж, дотооддоо төдийгүй олон улсад нэр хүндтэй, найдвартай түнш болохоо дахин нотлон харуулсан амжилттай жил байсан төдийгүй ТУЗ-ийн гишүүдийн банкийг үнэлсэн үнэлгээний дунджаар 2024 онд үйл ажиллагаа хэвийн буюу “**Сайн**” ажилласан гэж дүгнэж байна.

# НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА



# НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

ХХБ сүүлийн арав гаруй жилийн турш секторын хамгийн өндөр цалинтай банк болох зорилго тавин, жил бүр ажилтнуудынхаа цалинг 10-30 хувиар тогтмол өсгөж ирсэн. 2023 оноос ТУЗ-ийн шийдвэрээр нийт ажилтнуудыхаа цалингийн хэмжээг дөрвөн жилийн турш жил бүр 25 хүртэлх хувиар нэмэх "Зөгийн Үүр" хөтөлбөр хэрэгжүүлж эхэлсэн. Хөтөлбөр 2025 онд ч мөн хэрэгжиж ХХБ-ны мэргэжилтний дундаж цалин 1000 ам.долларт хүрлээ.

Уламжлал болсон худалдааны санхүүжилтийн форумаа зохион байгууллаа. "Тогтвортой хөгжилд хамтдаа" уриа дор зохион байгуулсан энэ жилийн форумд тогтвортой санхүүжилт, эрчим хүчний ирээдүй, нийлүүлэлтийн сүлжээний санхүүжилт зэрэг чухал сэдвүүдийг хөндлөө.

Швейцарын холбооны улсын Давос-Клостерс хотод зохион байгуулагдсан Дэлхийн Эдийн Засгийн Форумын 55 дахь удаагийн чуулга уулзалтад банкны удирдлагууд оролцлоо.

Ирээдүйн эрдэмтэн, инженер, инновацыг бий болгох Шинжлэх ухаан танин мэдэхүйг сонирхогч 1,000 гаруй залуусыг нэг дор цоглоосон #SciCon2025 арга хэмжээг дэмжин ажиллаа. Шинжлэх ухаан бол хүн төрөлхтний хөгжил дэвшил билээ.

Монгол улс дахь олон улсын хамгийн том боловсролын арга хэмжээ болох STEA-MEX 2025 дэмжин ажиллалаа. Мөн банкны үйл ажиллагаанд ашиглах боломжгүй техникийн хог хаягдлууд Дүдү хүүхдийн музейд хандивласан. Тухайн музей нь тус хог хаягдлыг шинжлэх ухаанд сонирхолтой бага настай хүүхдүүдийн дунд зохион байгуулах Workshop-доо ашиглах, ашиглаж дууссаны дараа байгальд ээлтэйгээр хог хаягдал дахин боловсруулдаг үйлдвэрт хандивлах юм.

Нийслэлийн ерөнхий боловсролын 55 дугаар сургуулийн Дауны тусгай ангийн номын санг номоор баяжуулж өглөө. Ийнхүү хязгааргүй мөрөөдөл төслөөрөө дамжуулан 60 сургууль цэцэрлэгийн 200 мянга гаруй хүүхэд, 10000 гаруй багш, сурган хүмүүжүүлэгчдийн боловсролд оюуны хөрөнгө оруулалт хийгээд байна.
Түүнчлэн төслийн хүрээнд ЭХЭМҮТ-ийн "Чих хамар хоолойн тасаг"-т 20 гаруй нэр төрлийн дурангийн хагалгааны иж бүрэн багаж хэрэгсэл бэлэглэлээ.
Мөн төслийн хүрээнд Дэлхийн Аутизмын сарыг тохиолдуулан Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвд Аутизмын тусгай ангийг иж бүрэн тохижуулж өглөө.



# НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА




Bloomberg TV Mongolia 2013 оноос эхлэн жил бүр Монгол Улсын эдийн засгийн өсөлт, хөгжил дэвшилд томоохон хувь нэмэр болсон хамгийн шилдэг бүтээн байгууллалт, хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр, бодлого шийдлийг "Bloomberg Awards"-т нэр дэвшүүлэн манлайлагчдыг тодруулж ирсэн. 2024 оноос тус санаачилгын дараагийн хуудсыг нээж, тогтвортой хөгжил, ногоон эдийн засагт хүргэх "хурдасгуур" болж буй шилдгүүд буюу "Catalyst"-г тодруулж эхэлсэн. Арга хэмжээний ерөнхий ивээн тэтгэгчээр Худалдаа Хөгжлийн Банк ажиллалаа.

## FRENCH - MONGOLIAN BUSINESSES VIP NETWORKING EVENT

Монгол Улс болон Бүгд Найрамдах Франц Улстай (БНФУ) дипломат харилцаа тогтоосны 60 жилийн ойн тэмдэглэлт түүхэн үйл явдлыг тохиолдуулан БНФУ-ын ЭСЯ-ны ивээл дор хоёр улсын банк санхүүгийн байгууллагуудын хамтын ажиллагааг улам гүнзгийрүүлэх зорилгоор тус улсын Bpi-france банктай хамтран Монгол-Франц улсын бизнес форумыг зохион байгууллаа.




Монгол Улсын арилжааны ууган банк Худалдаа Хөгжлийн Банк 35 жил ой дээрээ Үндэсний дээд лигийн сагсан бөмбөгийн "Эс Жи Эйпс" багийг ивээн тэтгэж, хамтран ажиллахаар боллоо. Энэхүү хамтын ажиллагаа нь Монголын сагсан бөмбөгийн спортыг шинэ түвшинд хөгжүүлэх, ирээдүйн тив, дэлхийн аваргуудыг төрүүлэх, хүүхэд залуусыг спортоор хичээллэхэд урам зориг өгөх чухал алхам юм.

## БИЗНЕСИЙН ОРЧИН

Тайлант онд Европын Холбоо – Монгол Улсын бизнес, хөрөнгө оруулалтын форум, European Christmas Party by TDB, CSR Awards Night 2025, Францын Үндэсний баярын арга хэмжээ, Annual Meeting of the New Champions, CEMENT EXPO 2025, SIBOS 2025, MinePro 2025 зэрэг арга хэмжээнүүдийг зохион байгуулж, дэмжин ажиллаа. Ингэснээр Худалдаа, хөгжлийн банк Монгол Улс болон гуравдагч хөрш улс хоорондын бизнесийн нөхцөл байдал, эдийн засаг, нийгмийн ач холбогдлыг сайжруулахад чухал үүрэг гүйцэтгэлээ.

# НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

**Bloomberg**
**LED MEDIA SCREEN**

Төр болон хувийн хэвшлийн байгууллагаас хэрэгжүүлж буй нийгэм, байгаль дэлхийн сайн сайхны төлөөх үйл ажиллагаануудыг дэмжиж ажиллав. Дэмжлэгийн хүрээнд 8 байгууллагын 16 төрлийн видеог төв байрны гадаа байрлах дэлгэцээрээ тус бүр 14 хоногоос дээш хугацаанд үнэгүй байршууллаа.

**BUSINESS**
**Networking & Certificate**
**Awarding Event**

Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгтэй хамтран Жижиг, дунд бизнесийн эрхлэгчдэд зориулсан "ЧАДАВХЖУУЛАХ ХӨТӨЛБӨР 2025"-г амжилттай зохион байгууллаа. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам байгуулагдсаны 100 жилийн ой, "Цагаан алт" үндэсний хөдөлгөөний хүрээнд зохион байгуулагдаж буй хүнс, хөдөө, аж ахуй, жижиг дунд үйлдвэрлэгчдийн үзэсгэлэн худалдаанд оролцлоо.

**SME DAY 2025**

JICA олон улсын байгууллагаас зохион байгуулсан SME Day 2025 арга хэмжээнд жижиг, дунд бизнес эрхлэгч харилцагч нараа оролцуулж, бүтээгдэхүүн, үйлчилгээний таатай нөхцөлөөр дэмжлээ. Эдгээр үйл явдал нь бизнес эрхлэгчдийн зах зээлд өрсөлдөх чадвар, эдийн засгийн чадавхыг нэмэгдүүлэх, салбарын хэмжээнд улсаас хэрэгжүүлж буй бодлогод хувь нэмэр оруулан дэмжлэг үзүүлэх том алхам болох юм.

**JICA**

JICA олон улсын байгууллагын санаачилгаар "Mongolia Open Innovation and Co-Creation for SDG's хөтөлбөр амжилттай зохион байгуулагдаж Худалдаа, хөгжлийн банк хамтран оролцлоо. ХХБ шилдэг таван төслийн нэг болох "HEV/EV хуучин батарейг дахин ашиглах технологийн хөгжүүлэлт" төслийг ивээн тэтгэлээ.

**World Health Organization**

World Health Organization Mongolia-тай эрүүл мэндийн чиглэлд хамтын ажиллагаа албан ёсоор эхлүүллээ. Энэ нь ДЭМБ-ын Монгол Улс дахь Суурин төлөөлөгчийн газар хувийн хэвшилтэй байгуулж буй анхны хамтын ажиллагаа гэдгээрээ онцлог. Бид олон нийтэд эрүүл мэндийн мэдлэгийг нэмэгдүүлэх, урьдчилан сэргийлэх зөвлөмжийг түгээхэд дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.

**НЭГ ТОР – НЭГ ДЭЛХИЙ**

Банкны гадаад болон дотоод хэрэгцээнд ашигладаг гялгар торын хэрэглээг бүрэн халж, байгальд бордоо болон шингэдэг эко тор ашигладаг боллоо.